



# МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

79

1998 оны 7 дугаар  
сарын 28-дөрөн

Дугаар 0-125

Улаанбаатар  
хот

## Дүрэм батлах тухай

Нэг. "УСАГ" ХХК (Ус суваг ашиглалтын газар)-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү дүрэмд нийцүүлэн байгууллагын дотоод журмыг боловсруулан баталж, иргэний гэрээ байтуулан ажиллахыг "УСАГ" ХХКомпани (н.Эрдэнэбаатар)–д үүрэг болгосугай.

Төрөл. Энэ захирамж гарсантай холбогдуулж "Дүрэм батлах тухай" нийслэлийн Засаг даргын 1995 о. ны А/ 107 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



Ж.НАРАНЦААРЛТ



## "УСАГ" ХХК (ҮҮГ)-НИЙ ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хуулийн этгээд болох Ус сувгийн ашиглалтын газар (цаашид "газар" гэх) нь Монгол улсын Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль нөхөрлөл, компанийн хуулийн дагуу Төрийн өмчид үндэслэн байгуулагдсан хязгаарлагдмал хариуцлагатай компани (улсын үйлдвэрийн газар) хэлбэрээр оршино.

1.2. Газар нь "УСАГ" гэж нэрлэгдэх бөгөөд төв нь Улаанбаатар хотод байрлана.

1.3. Газрын албан ёсны байршил нь Нийслэлийн Баянзүрх дүүрэг 3 дугаар хороо, Хөх тэнгэрийн гудамжны нутаг дэвсгэрт байрлана. Утас 450120.

1.4. Газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний түйлгээнд ордог хуулийн этгээдийн эрх зүйн байдалтай ХХКомпани (улсын үйлдвэрийн газар) юм.

1.5. Газрын дурмийн сангийн нийт хэмжээ 1538,4 сая төгрөг байна.

- a) Үндсэн хөрөнгө 857,9 сая
- б) Эргэлтийн хөрөнгө 680,5 сая

1.6. Газар нь аж ахуйн тооцоон дээр орлогоороо үйлдвэрлэлийн зардлаа нөхөж ажиллана.

Хоёр. Газрын үйл ажиллагааны зорилго чиглэл, эрх хэмжээ

2.1. Газрыг байгуулах тухай Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн шийдвэр гарсан өдрөөс байгуулагдсанд

тооцох ба Нөхөрлөл компаний тухай хуулинд заасанд журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

**2.2. Газрын үндсэн зорилт нь Нийслэлийн хүн ам, байгууллага аж ахуйн нэгжийн үнд-ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар тасралтгүй хангаж, гарсан бохир усыг татан зайлцуулж цэвэрлэхэд оршино.**

**2.3. Газар нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрын байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролцож эрхтэй.**

**2.4. Газар нь үндсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд өөрийн салбарыг нээн ажиллуулж болно.**

**2.5. Газар нь цэвэр, бохир усны үнийг тогтоох санал оруулах эрхтэй бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай зөвшүүлж шийдвэр гаргана.**

**2.6. Газар нь өөрийн тамга, тэмдэг, бичгийн хэвлэмэл хуудастай байна.**

**2.7. Үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардагдах түүхий эд, материалыг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.**

**2.8. Газар нь дараах эд хөрөнгийн эрх, үүрэгтэй.**

**а)Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж энэ дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж ашиглах:**

**б) Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжид заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулах:**

**в) Улсын төсвөөс олгосон хөрөнгийг төсвийн хууль, зардлын зориулалтаар нь зарцуулж тайлагнах:**

**г) Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр өөрөө мэдэж дүрмийнхээ зорилтын дагуу захиран зарцуулах;**

д)Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулианд заасан журмыг баримтлана.

### 2.9.Газар нь дор дурдсан үйл ажиллагааг явуулна.

а)Нийслэлийн хүн ам, байгууллага, аж ахуй нэгжийн усны хэрэгцээг унд–ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар байнга тасралтгүй хангах.

б)Бохирдсон усыг зохих шаардлагын дагуу цэвэрлэж зайлцуулах.

в)Хэрэглэгчдийн усны алдагдлыг бууруулах, усны бохирдолтын хэмжээнд хяналт тавих.

г)Цэвэр, бохир усны стандартын түвшинд технологийн лабораторийн шинжилгээг гүйцэтгэх.

### Гурав.УСАГ–ын үүсгэн байгуулагчийн бүрэн эрх

3.1.Газрын үүсгэн байгуулагч нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч байх буюу хуулианд заасан эрх эдлэнэ.

3.2.Газар нь Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны харьцанд үйл ажиллагаагаа явуулна.

3.3.Нийслэлийн Өмчийн газар нь төрийн өмчийн төлөөллийг хуулианд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хэрэгжүүлнэ.

3.4.Улаанбаатар хотын Ерөнхий менежер болон Өмчийн газар нь үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн доорхи бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

а)Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах ажлыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянах:

б)Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжэ авах:

в) Нийслэлийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалт, цалин хөлсний норм, нормативыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох:

г) Орон нутгийн өмчийг удирдах ажилд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх:

д) Захиалгын үндсэн дээр нийслэлийн байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах:

е) Нийслэлийн омчит хуулийн этгээдийн үл хөдлиөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шийдвэр гаргуулах:

ё) Газрын захирлыг томилох, чөлөөлөх санал тавьж захиралтай холбогдох хуулинд заасан нөхцлийг хангасан болон үйл ажиллагааных нь онцлогийг харгалзан тусгасан нөхцөлтэй гэрээ байгуулах, омч хөрөнгийг захиран зарцуулах талаархи түүний эрх хэмжээг тогтооно.

ж) Захирлын дэргэдэх зөвлөлийн гишүүдийг томилох:

з) Газрын жилийн болон хэтийн төлөвлөгөө, төсөв, жилийн тайлан тэнцлийг хянан батлуулах:

и) Газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах тухай саналаа тавих:

й) Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах санал тавих.

### **Дөрөв. Газрын удирдлага**

4.1. Газрын үйл ажиллагааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн томилсон захирал удирдана.

4.2. Захирал нь Улаанбаатар хотын захирагч түүний албаны өмнө ажлаа хариуцан тайлагнана.

4.3. Захирлын дэргэд нь шаардлагатай мэргэжилтэн, албан тушаалтныг оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл ажиллана.

4.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Улаанбаатар хотын Ерөнхий мснс жер томилино. Уг зөвлөлд төрийн өмчийн төлөөлөгч, НЭДТГазар,

Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны ажилтан заавал орох бөгөөд бусад гишүүнээр хэнийг ч томилж болно.

4.5.Зөвлөл нь тус газрын бизнес төлөвлөгөө, аппаратын зохион байгуулалт, бүтэц, цалингийн сан, урамшууллын журам, тайлан баланс, дүрмийн сангийн хэмжээ болон захирлын үйл ажиллагаа, эрх хэмжээ, түүнийг өөрчлүүлэх талаар дүгнэлт гаргаж, үүсгэн байгуулагчид санал, зөвлөмж гаргах эрхтэй.

4.6.Зөвлөл нь захирал болон газрын үйл ажиллагаанд дотоодын хяналт тавих үүрэгтэй.

#### 4.7.Захирал дараах эрх, үүрэгтэй

а) Газрыг гадаад дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх, итгэмжлэл олгох

б) Газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж гэрээнд заасан эрх хэмжээний дотор захирсан зарцуулах

в) Газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж Улаанбаатар хотын захирагчаар батлуулан биелэлтийг хангах

г)Газрын захиргааны бүтцийг тогтоож ажилтанг томилох, чөлөөлөх, Улаанбаатар хотын захирагчаас тогтоосон цалингийн бүдүүвч, сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох

д)Газрын үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтоох

е)Хөдөлмөрийн хууль тогтоомжид нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлэх

ё)Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж тэдгээрийн үнэн зөвийг хариуцах

ж)Маргаантай асуудлаар газраа төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах

3)Улаанбаатар хотын захирагч түүний ажлын албатай зөвшлилсөний үндсэн дээр бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнэ, тарифыг тогтоох

и)Эрх хэмжээнийхээ асуудлаар газрын хэмжээнд дагаж мөрдөх, тушаал, заавар гаргах

й)Хууль тогтоомжид заасан бусад эрх үүрэг.

4.8.Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс газрын нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.

4.9.Захирал бусад хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргаанд буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

4.10.Захирлын буруутай үйл ажиллагаа болон холбогдох хууль, тогтоомж, энэ дүрэм, гэрээнд заасан эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашигласнаас учирсан хохирлыг өөрийн хувийн эд хөрөнгөөр бүрэн хариуцина.

#### **Тав Санхүү, бүртгэл, хяналтын систем**

5.1.Санхүү бүртгэлийн систем нь Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдана.

5.2.Газрын санхүүгийн жил нь тухайн оны I дүгээр сарын 1 иээс эхэлж, 12 дугаар сарын 31 ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь газар байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31 ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь газрыг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3.Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4.Газар нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, Татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.5.Газар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн эзлэгдэл хоригдлын шимтгэлийг тооцно.

5.6. Газрын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжид заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7. Газрын удирдлага нь газрын үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.8. Газрын тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй бусад мөнгөн хөрөнгө, түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр, шаардлага зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөгт хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

### Зургаа. Татан буулгах

6.1. Газрыг татан буулгах шийдвэрийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон хуульд заасан үндэслэлээр гаргаж болно.

6.2. Газрыг татан буулгах тохиолдолд үүсгэн байгуулагчаас томилсон комисс татан буулгах ажлыг эрхлэнэ.

6.3. Татан буулгах комисс нь дуусгалтын тайлан баланс гаргаж, үүсгэн байгуулагчид танилцуулна.

6.4. Газрыг татан буулгах тохиолдолд нийтэд мэдээлж өр төлбөрийг хуульд заасан дараалал журмын дагуу төлсний дараа үндсэн хөрөнгийг 3 сарын дараа үүсгэн байгуулагчид шилжүүлнэ.

### Долоо. Бусад асуудал

7.1. Энэхүү дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Монгол улсын бүртгэлийн болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүлнэ.

7.2. Энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.